



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/02

Улаанбаатар хот

“Багахангай тохижилт” Орон нутгийн өмчит аж
ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон
тоо, цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Багахангай тохижилт” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоог нэгдүгээр, цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захиралтай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

3. Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан шинэчлэн тогтоосон цалингийн хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал (Б.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” A/10 дугаар тогтоол, 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн “Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын зарим албан тушаалтны цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” A/22 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ